

МОНГОЛ УЛСЫН ЦӨМИЙН ЗЭВСЭГГҮЙ БҮСИЙН СТАТУСЫГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙГЭЭР БАТАЛГААЖУУЛАХ АСУУДАЛД

Д.Оюунсүрэн *

1992 оны 9-р сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 47-р чуулганы индэр дээрээс Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг дэлхий нийтэд зарлан тунхагласан нь манай улсын бие даасан, хараат бус гадаад бодлогын анхны томоохон алхам болсон билээ.

Түүхийн хуудсыг сөхөн үзвэл АНУ-ын зэвсэгт хүчин дэлхийн 2-р дайныг хурдавчлан дуусгах зорилгоор 1945 оны 8-р сарын 6-нд Японы Хирошима, 8-р сарын 9-нд Нагасаки хотуудад цөмийн бөмбөг дэлбэлсэн нь түүний асар их хөнөөх чадал, учруулж болох гай гамшгийг хүн төрөлхтөнд ойлгуулсан билээ. Хирошимад хаясан бөмбөг 140 мянга, Нагасакид хаясан бөмбөг 70 мянга гаруй гэмгүй хүний амийг авч одон, 100 мянга гаруй хүн шархадсан юм.⁵ Гэвч энэхүү цоо шинэ төрлийн зэвсгийн шууд бус үр дагавар хамгийн аймшигтай байлаа. Дөнгөж долоо хоногийн дараагаас цацраг туяаны өвчнийг судалж эхэлсэн бөгөөд цацраг идэвхт бодисонд хордон шаналсан хүний тоо 400 мянга хол давж байв.⁶

Харамсалтай нь энэхүү хөнөөлт зэвсгийг өөрсдийн аюулгүй байдлыг бэхжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах гэсэн ухвар мөчид бодлогоос үүдэн олон улс гүрэн цөмийн зэвсэгтэй болохыг улайран хөөцөлдөж, нэлээдгүй нь түүндээ хүрээд байна. Тухайлбал, 1949 онд ЗХУ, 1952 онд Их Британи, 1960 онд Франц, 1964 онд БНХАУ, 1974 онд Энэтхэг, 1998 онд Пакистан, 2006 онд Хойд Солонгос зэрэг улс цөмийн туршилт хийж цөмийн зэвсэгтэй орнуудын эгнээг өргөжүүлэн тэлээд байгаа юм. Түүнээс гадна, Израиль улс албан ёсоор цөмийн зэвсэгтэй гэдгээ зарлаагүй боловч судлаачид тус улсыг цөмийн зэвсэгтэй орон гэж үздэг. Мөн Иран улсын сэжиг бүхий цөмийн хөтөлбөр олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг түгшээсээр байгаа билээ.

Монгол Улсын улсын хувьд түүхэн хувь тохиолоор цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршдог, тэдгээр хөршийнхөө дундах жийргэвчийн үүрэг гүйцэтгэсээр ирсэн зэрэг нь манай улсын үндэсний аюулгүй байдлын нэгэн эмзэг тал билээ. Хэдийгээр бид олон улсын харилцаанд бий болсон нааштай уур амьсгалын дүнд 1990-д оноос эхлэн хоёр хөрштэйгээ тэнцвэртэй, найрсаг харилцааг хөгжүүлж ирсэн боловч олон улсын харилцаа, аюулгүй байдлын

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

⁵ "Всемирная история" Т.24. Минск. 1997, стр.556

⁶ Там же.,

орчин өөрчлөгдсөн нөхцөлд тэдгээрээс ирэх аюул заналыг урьдчилан тааварлах аргагүй билээ. Нөгөө талаас ОХУ болон БНХАУ-ын цөмийн туршилт хийдэг байсан талбайнууд манай нутаг дэвсгэрээс холгүй оршдог бөгөөд цөмийн туршилтаас үүдэлтэй цацраг идэвхт бодисын хор манай хил орчмын нутгийн байгаль орчин, хүн амд хэрхэн нөлөөлсөн буюу нөлөөлж байгаа талаар тусгайлан судалгаа хийх шаардлага нэгэнт бий болоод байна. Тодруулбал, ЗХУ 1949-1990 оны хооронд хийсэн 715 цөмийн туршилтынхаа дийлэнх хувь буюу 456 туршилтыг Казакстаны нутагт орших Семипалатинскийн цөмийн туршилтын талбайд хийсэн¹ бол БНХАУ 1964-1996 оны хооронд 45 цөмийн туршилтыг² Шинжан-Уйгарын өөртөө засах орны нутагт орших Лоб нуурын цөмийн туршилтын талбайд хийжээ. Түүнээс гадна, энхийн зорилгоор олон тооны цөмийн дэлбэлэлтийг манай улсын ойр орчимд хийж байсныг дурдвал Читад 1977 онд нэг удаа, Кемеровад 1984 онд нэг удаа, 1977-1982 онд Эрхүүд 2 удаа, 1966-1979 онд Казакстаны Азгирт 17 удаа³ тус тус хийсэн байна.

Цөмийн зэвсэг хэрэглэх явдлыг олон улсын эрх зүйгээр бүрэн хориглоогүй, цөмийн зэвсгийг хэрэглэх эрсдэл бүрэн арилаагүй байгаа өнөөгийн нөхцөлд Монгол улс өөрийн цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм.

Цөмийн зэвсгийн аюул, түүнийг хэрэглэхийг хориглох асуудал

Хэдийгээр Хирошима, Нагасаки хотод цөмийн бөмбөг хаяж, олон зуун мянган хүний амь насыг хохироож, түүнээс ч олон хүнийг удам дамжсан цацрагийн хордлогын золиос болгосон аймшигт явдлаас хойш хүн төрөлхтөн цөмийн зэвсгийг хэн нэгнийхээ эсрэг шууд хэрэглээгүй боловч асар хөнөөлт энэхүү зэвсгийг хэрэглэх явдлыг олон улсын эрх зүйгээр бүрэн хориглоогүй байгаа нөхцөлд түүнээс учруулах аюул бодитойгоор оршсоор байгаа билээ.

Цөмийн зэвсгийг хориглох асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассемблей хэд хэдэн тогтоол батлан гаргасан байдаг. Тухайлбал, 1961 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблей “Цөмийн зэвсэг хэрэглэх нь хууль бус тухай тогтоол” баталсан бөгөөд түүнийг 55 улс дэмжиж, 20 улс эсэргүүцэж, 26 улс түдгэлзсэн байна.⁴ Энэ нь нэг талаас цөмийн зэвсгийг хориглох асуудлын талаар улсууд нэгдсэн байр суурьт хүрч чадаагүйг илтгэж байгаа бөгөөд нөгөө талаас Ерөнхий Ассемблейн тогтоол хууль зүйн хүчин чадлын хувьд заавал биелэгдэх шинжгүй гэдгийг дурдах ёстой. Түүнчлэн Ерөнхий Ассемблей 1972 онд “Олон улсын харилцаанд хүч үл хэрэглэх, цөмийн зэвсгийг хэрэглэхийг эгнэгт хориглох тухай” тунхаглалыг баталсан. Эдгээр баримт бичигт цөмийн зэвсгийг хэрэглэх нь НҮБ-ын дүрмийн үзэл санаа, зорилгод харшилсан үйлдэл бөгөөд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болно гэж тунхагласан билээ. Харамсалтай нь эдгээр тунхаглал цөмийн зэвсэгтэй бүх гүрний дэмжлэгийг авч чадаагүй байгаа юм.⁵

¹ <http://nuclearweaponarchive.org/Russia/Sovtestsum.html>

² http://en.wikipedia.org/wiki/List_of_nuclear_tests

³ <http://www.ctbto.org/map/#testing>

⁴ Peter Malanczuk, Akehurst's Modern Introduction to International Law, 7th revised edition, Routledge 1997, p.346

⁵ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, “Олон улсын эрх зүй”, Улаанбаатар 1999, 260-р тал

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1982 онд “Цөмийн зэвсгийг хэрэглэхийг хориглох тухай” конвенци боловсруулахыг Зэвсэг хураах бага хуралд анх зөвлөмж болгосон бөгөөд уг асуудлаар хэлэлцээ явуулж эхлэхийг зөвлөмж болгож, Коста Рика улсын санал болгосон конвенцийн төслийг 1997 онд шилжүүлсэн юм⁶. Нэлээд олон жил шийдвэрлэгдэж чадаагүй уг асуудалд сүүлийн жилүүдэд ахин анхаарал хандуулах болсон бөгөөд тодруулбал 2006 оны 12-р сард НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганы үеэр 125 улсын засгийн газар, түүний дотор цөмийн зэвсэгтэй Хятад, Энэтхэг, Пакистан зэрэг улс цөмийн зэвсгийг бүтээх, үйлдвэрлэх, турших, байршуулах, хадгалах, шилжүүлэх, хэрэглэх болон түүгээр заналхийлэхийг хориглож, цөмийн зэвсгийг устгах нөхцлийг хангах зорилготой “Цөмийн зэвсгийн конвенци”-ийг хойшлуулалгүй байгуулахын тулд олон талт яриа хэлэлцээ явуулж эхлэхийг уриалсан билээ. Уриалгын мөрөөр 2007 онд “Цөмийн дайнаас сэргийлэхийн төлөө олон улсын эмч нар” байгууллага “Цөмийн зэвсгийг устгах олон улсын компанит ажил”-ыг эхлүүлж, 1997 онд Коста Рика улсын дэвшүүлж байсан конвенцийн төсөл дээр үндэслэсэн “Цөмийн зэвсгийн конвенци”-ийн төслийг боловсруулсан бөгөөд уг конвенцийг байгуулахаар засгийн газрууд, олон улсын байгууллага, иргэний нийгэм, олон нийтийг хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна. Тэдний үзэж байгаагаар хэрэв засгийн газрууд хандлагаа өөрчлөх аваас Цөмийн зэвсгийн конвенцийг тун богино хугацаанд байгуулж болно. Тухайлбал, “Цөмийн зэвсгийг агаар мандал, сансрын уудам, усан доор туршихыг хориглох тухай гэрээ”-г 1963 оны 7-р сард аравхан өдрийн дотор хэлэлцэн байгуулж байсан”⁷.

Зарим олон улсын эрх зүйчид хэдийгээр цөмийн зэвсэг нь асар их хор хөнөөл учруулдаг боловч мөн цэрэг дайны асар их давуу тал олгодог гэсэн үндэслэлээр цөмийн зэвсэг хэрэглэх явдлыг зөвтгөдөг. Тухайлбал, Нидерланд улсын Эрасмусын Их сургуулийн олон улсын эрх зүйн профессор Петер Маланкзук 1945 онд Японы эсрэг цөмийн бөмбөг хэрэглээгүй бол дайн ахиад хэдэн жил үргэлжлэх байсан гэж дүгнэсэн байдаг⁸. Гэхдээ дийлэнх судлаачид цөмийн зэвсгийг хэрэглэхийг ямар ч үед зөвтгөх нь хүн төрөлхтний эсрэг чиглэсэн хүмүүнлэг бус үйлдэл гэж үздэг. Тийм ч учраас, олон улсын хамтын нийгэмлэг энэхүү хөнөөлт зэвсгийг хэрэглэх явдлыг олон улсын эрх зүйгээр ойрын ирээдүйд хориглож чадна хэмээн итгэж байна. “Хэзээ нэгэн цагт цөмийн зэвсэг газрын хөрснөөс арчигдах болно”⁹ хэмээн АНУ-ын Ерөнхийлөгч Рейган 1985 оны 1-р сард хоёр дахь удаагийн тангараг өргөх ёслол дээрээ хэлсэн нь биелэх цаг ирэх буй за.

Цөмийн зэвсгийг хэрэглэх нь хууль ёсны эсэх талаар Олон Улсын Шүүхийн (ОУШ) зөвлөх дүгнэлт гаргуулахаар 1993 оны 9-р сарын 3-нд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), 1996 оны 1- сарын 6-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблей тус тус хүсэлт-тавьсан байна. ОУШ 1996 оны 7-р сарын 8-нд дээрх хоёр хүсэлтийн талаар зөвлөх дүгнэлт гаргасан юм. ДЭМБ-ын тавьсан хүсэлтийг олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд даган мөрддөг “төрөлжих зарчмын” дагуу тус байгууллага нь “цөмийн зэвсгийг хэрэглэх нь хууль ёсны эсэх” талаар асуудлыг хөндөх эрх зүйн аливаа чадамж байхгүй гэсэн

⁶ Мөн тэнд, 261-р тал

⁷ <http://www.icanw.org/nuclear-weapons-convention>

⁸ Peter Malanczuk, Akehurst's Modern Introduction to International Law, 7th revised edition, Routledge 1997, p.347

⁹ New York Times, 22 January 1985

үндэслэлээр хүлээн аваагүй. Ерөнхий Ассемблейгаас тавьсан хүсэлтийн тухайд ОУШ-ийн шүүгчид цөмийн зэвсгийг хэрэглэх буюу түүгээр заналхийлэлийг зөвшөөрсөн ямарваа зөвшөөрөл олон улсын заншлын хэм хэмжээ болон олон улсын эрх зүйд байхгүй гэдэгтэй санал нэгдсэн боловч “цөмийн зэвсгийг иж бүрэн, түгээмэл хориглосон” зүйл мөн байхгүй гэж үзсэн (11 дэмжиж 3 татгалзсан). Цааш нь нийт шүүгчдийн санал тэнцэж, шүүхийн Ерөнхийлөгчийн таслах саналаар “Олон улсын эрх зүйн одоогийн байдал болон өөрт байгаа баримтуудыг харгалзан, Шүүх цөмийн зэвсгийг хэрэглэх буюу түүгээр заналхийлэх явдал хууль ёсны эсэх талаар эцэслэн шийдвэрлэх боломжгүй”¹⁰ хэмээн үзсэн. Хэрэв тэр үед ОУШ-ээс цөмийн зэвсгийг хэрэглэх нь олон улсын эрх зүйд харш гэсэн шийдвэр гаргасан бол даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, хүн төрөлхтний амар амгалан амьдрал, хөгжил цэцэглэлтэд оруулах маш том хувь нэмэр, түүхэн үйл явдал болох байсан билээ.

ОУШ-ийн 15 шүүгч 9 жилийн хугацаагаар томилогддог тул тодорхой хугацааны дараа ОУШ-ийн өөр бүрэлдэхүүн дээрхээс ялгаатай шийдвэр гаргаж болох юм. Тийм ч учраас Египетийн судлаач Мухаммед Эль Шакер НҮБ-ын Ерөнхий Ассемблейн зүгээс ОУШ-д цөмийн зэвсгийг хэрэглэх нь хууль ёсны эсэх талаар зөвлөх дүгнэлт гаргуулахаар дахин хандах хэрэгтэй¹¹ хэмээн үзэж байгаа нь туйлын зөв юм.

Нөгөө талаар “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ”, “Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай гэрээ”-нд нэгдэн орсон болон цөмийн зэвсэггүй бүсүүдэд хамрагдах улс орнуудын тоо нэмэгдэж байгаа нь цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс цөмийн зэвсгээ тархаах нөхцөл бололцоог хумиж, өөрсдийн нутаг дэвсгэрээс гадна уг зэвсгийг байрлуулах явдлыг хязгаарлаж байгаа юм. Энэ нь эцсийн дүндээ, цөмийн зэвсгийг хууль ёсоор эзэмших явдлыг улам багасгаж байгаа билээ¹².

Цөмийн зэвсгийг хэрэглэх эрсдэл бодитойгоор оршсоор байгаа тухайд

ЗХУ задран унаж, хүйтэн дайн дуусгавар болоход олон судлаачид цөмийн дайны бодит аюул занал үгүй боллоо хэмээн дүгнэж байсан нь ташаа байжээ гэдэг нь улам тодорхой болсоор байна. Хэдийгээр ЗХУ, АНУ-ын цөмийн сэргөлдөөн үгүй болсон боловч цөмийн зэвсгийг хэрэглэх эрсдэл байсаар байгаа төдийгүй өсөн нэмэгдэж байна. Өдөр бүр 6000 гаруй тив алгасагч пуужингийн цөмийн цэнэгт хошуу өндөр хэмжээний түгшүүрийн бэлэн байдалд байсаар байна¹³.

Хэрэв ОХУ, эсвэл АНУ-ын Ерөнхийлөгч “Манай улс цөмийн пуужингийн дайралтад өртлөө” гэсэн мэдээлэл авбал түүнд цөмийн товчлуурыг дарах эсэхээ шийдэхэд хамгийн ихдээ 10 минутын хугацаа шаардлагатай байдаг. Зарим хүн хүйтэн дайн нэгэнт дуусч ОХУ ба АНУ хоёр сэргөлдөгч дайснууд

¹⁰ Peter Malanczuk, Akehurst's Modern Introduction to International Law, 7th revised edition, Routledge 1997, p.349

¹¹ Mohamed Ibrahim Shaker, The Evolving International Regime of Nuclear Non-Proliferation, Belles pages shaker ok.qxd 2007, p.110

¹² H. Müller, K. Frank, A. Kelle, S. Meier und A. Schaper: Nukleare Abrüstung - mit welcher Perspektive? Der internationale Diskurs über die nukleare Rüstungskontrolle und die Vision einer kernwaffenfreien Welt, HSFK-Report 8/1996

¹³ IPPNW North Asian Regional Meeting: Documents and Proceedings, 21-22 June, 2007, Ulaanbaatar, Mongolia, p. 15

байхаа больсон тул ямар ч цөмийн дайны эрсдэл байхгүй гэж боддог. Тэгвэл ямар ч эрсдэл байхгүй юм бол яагаад ийм олон цэнэгт хошуу байнгын түгшүүрийн бэлэн байдалд байсаар байна вэ? Ийм бэлэн байдал нь хэд хэдэн сөрөг үр дагаврыг өдүүлж болно. Тухайлбал, техникийн алдаа, хүнээс шалтгаалах алдаа, хакерууд болон террористуудын халдлага¹⁴ зэргийг дурдаж болох юм. Ганц жишээ дурдахад, Осама Бин Ладен цөмийн зэвсгийг сонирхож байгаагаа удаа дараа илэрхийлж байснаас гадна Пакистаны эрдэмтдээр дамжуулан цөмийн материал олж авахыг хэд хэдэн удаа оролдсон нь түгшүүрийн харанга дэлдэж байна. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудын нутаг дэвсгэр дээр оршдог цөмийн цахилгаан станцууд болон цөмийн материалын аюулгүй байдал ч мөн анхаарал татаж байгаа юм. ОХУ-ын албаны хүмүүсийн мэдэгдэж байгаагаар сүүлийн жилүүдэд тус улсын нутаг дэвсгэрээс 500 гаруй удаа цөмийн материал хууль бусаар хил давуулах оролдлого хийгджээ¹⁵. Түүнчлэн Олон улсын Цөмийн энергийн комиссын УЦЭК-ийн “Хууль бус наймааны мэдээллийн сан”-д 2004 оны 1-р сарын байдлаар цөмийн материал хулгайлсан 662 тохиолдол, түүний дотор өндөр хэмжээнд баяжуулсан уран, плутон хулгайлсан 18 хэрэг бүртгэгдсэн байна¹⁶.

Дээрхийн алинаас нь ч шалтгаалж бүс нутгийн буюу дэлхийн хэмжээний цөмийн дайн үүсч болно гэдгийг бид үргэлж санах учиртай. Тийм ч учраас 2007 оны 1-р сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Жорж Шульц, Хенри Киссинжер нар болон АНУ-ын Батлан хамгаалахын сайд асан Уильям Перри, Сенатын Зэвсэгт хүчний байнгын хорооны дарга асан Сэм Нанн нар цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийг бий болгохыг уриалж тодорхой санал дэвшүүлсний дотор цөмийн зэвсгийн сэрэмжлүүлэх хугацааг уртасгаж, ингэснээрээ санамсаргүйгээр буюу зөвшөөрөлгүйгээр цөмийн зэвсэг ашиглах аюулыг бууруулахыг санал болгосон нь¹⁷ маш зүйтэй алхам болсон юм.

Нөгөөтэйгүүр, томоохон цөмийн гүрнүүд цөмийн шинэ номлолыг дагах болсон нь туйлын аюултай хэрэг бөгөөд түүгээр бол цөмийн зэвсгийг ердийн зэвсэглэлийн нэг хэсэг гэж үзэх болсон. Энэ оны 1-р сард НАТО-гийн дээд тушаалын албан хаагч асан 5 хүн “Шинэ НАТО-гийн тунхаглал” хэмээх баримт бичгийг нийтэлж нэлээд шуугиан тарьсан юм. Уг тунхаглалд “Цөмийн зэвсэг цаашид тархах эрсдэл оршсоор байгаагийн хамт хязгаарлагдмал хүрээнд цөмийн дайн гарах аюул нүүрлэсээр байна. Цөмийн зэвсгээр түрүүлж цохилт өгөх явдал нь үй олноор хөнөөх зэвсгийг хэрэглэхээс сэргийлэх эцсийн арга хэрэгсэл байх ёстой...Цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийг бий болгох бодит боломж алга байгаа учраас түрүүлж цөмийн цохилт өгөх явдал амин чухал арга хэрэгсэл байх болно.”¹⁸ гэж дурдсан нь энхийг эрхэмлэгч хүн бүрийн дургүйцлийг хүргэсэн билээ. Түүнээс гадна АНУ Ираны эсрэг “урьдчилан сэргийлэх цөмийн дайн” явуулж болох тухай ил тодоор ярих болсон нь маш ноцтой үр дагавар авчирч болзошгүй юм¹⁹.

¹⁴ Ibid

¹⁵ Wolfgang Kötter, *Nuklear Terrorismus :Geklaut wird überall*, Freitag 16, 21.April 2006

¹⁶ Mohamed Ibrahim Shaker, *The Evolving International Regime of Nuclear Non-Proliferation*, Belles pages shaker ok.qxd 2007, p.111

¹⁷ George P. Shultz, William J. Perry, Henry A. Kissinger and Sam Nunn, *A World Free Of Nuclear Weapons*, The Wall Street Journal, 4 January 2007

¹⁸ Ian Traynor, *Pre-Emptive Nuclear Strike a Key Option*, Nato Told, The Guardian, 22 January 2008

¹⁹ IPPNW North Asian Regional Meeting: Documents and Proceedings, 21-22 June, 2007, Ulaanbaatar, Mongolia, p. 15

Хүйтэн дайн дууссанаас хойш стратегийн цөмийн зэвсгийн тоо буурсан нь үнэн боловч 2008 оны байдлаар АНУ 4075, ОХУ 5189, Франц 348, Их Британи 185, БНХАУ 176 цөмийн цэнэгт хошуутай байна. Албан ёсоор цөмийн зэвсэгтэй хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр орнуудаас гадна Энэтхэг 60-70, Пакистан 60, Израиль 80 цөмийн цэнэгт хошуутай гэсэн тооцоог Стокгольмийн Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэн²⁰ гаргасан байна. Энэ бол дэлхий ертөнцийг тэр чигээр нь хэд дахин устгахад хүрэлцэхүйц хэмжээний тоо юм. Зөвхөн ганц энэ тооноос харахад “цөмийн дайн хэзээ ч болохгүй гэдэг үзэл бол дэндүү гэнэн хэрэг” хэмээн Коннектикутын Их сургуулийн профессор Жон Т.Рурке²¹ үзсэнтэй санал нэг байна. Тийм ч учраас Монгол улс өөрийн цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах нь цөмийн аюул заналаас улс орноо сэргийлэх, бүс нутагтаа болон дэлхий дахинд энх тайвныг сахин хамгаалахад чухал ач холбогдолтой билээ.

Цөмийн зэвсэггүй бүсийн статус Монгол Улсын хувьд ямар ач холбогдолтой вэ?

XX зууны туршид улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт умард хөрш ЗХУ-аас туйлын хараат байдалд байсан, үндэсний язгуур эрх ашгаа дээдлэх бус харин социалист хамтын нөхөрлөлийн явцуу эрх ашигт хүлэгдсэн, үзэл сурталжсан гадаад бодлого явуулж ирсэн Монгол улсын хувьд олон тулгуурт, нээлттэй, биеэ даасан гадаад бодлого явуулах нь цоо шинэ зүйл байсан гэдэгтэй маргах хүн гарахгүй буй за. Монгол улсын хувьд юуны түрүүнд энэхүү шинэ гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлалаа ул суурьтай тодорхойлж томъёолох шаардлага зүй ёсоор урган гарсан бөгөөд 1994 онд УИХ-аас Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал хэмээх бодлогын хоёр баримт бичгийг батлан гаргасан билээ.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулж, аюулгүй байдлаа улс төрийн аргаар бэхжүүлэх чухал тулгуур болгох”²² нь Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах арга замын нэг гэдгийг тодорхойлсон. Тэрчлэн Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй, гадаадын цэрэг, зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хенсэх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтална”²³ хэмээн заасан.

Цөмийн зэвсэггүй бүсийн статус Монгол Улсын хувьд ямар ач холбогдолтой талаар судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн байдгаас заримыг нь авч үзье. Судлаач С.Галсанжамцын үзэж буйгаар цөмийн зэвсэггүй бүсийн статус Монгол улсын хувьд дараах ач холбогдолтой юм. Үүнд:

²⁰ Stockholm International Peace Research Institute, SIPRI Yearbook 2008 :Armaments, Disarmament and International Security, Sweden 2008 ,p.16

²¹ John T.Rourke, International Politics on the World Stage, 9th Edition, McGraw-Hill/Dushkin 2003, p.360

²² Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Улаанбаатар 1994, 23-р зүйл

²³ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, Улаанбаатар 1994, 9-р зүйл

- Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэлхийн хамтын нийгэмлэг, тэр дундаа цөмийн зэвсэгтэй улсууд хүлээн зөвшөөрч, НҮБ дэмжсэн нь манай орны олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Манай санаачилгыг цөмийн зэвсэг бүхий улсуудын зүгээс (ялангуяа Хятад, ОХУ) нааштайгаар хүлээн авсан нь Монгол улсын аюулгүй байдлын орчинг улам таатай болгож байна.
- Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь цөмийн аюулыг багасгах, үй олноор хөнөөх зэвсгийг хязгаарлах дэглэмийг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэхийн зэрэгцээ бүс нутгийн аюулгүй болон тогтвортой байдалд нааштай нөлөө үзүүлнэ. Бүс нутгийн болон улсуудын хоорондын харилцаа нь тогтвортой байгаа үед цөмийн зэвсэггүй бүсийн ач холбогдол нь өндөр байж, харин хямралт харилцааны үед цөмийн зэвсэггүй бүсийн үр нөлөө буурдаг. Энэ утгаараа, Монгол улсын нэг улс-цөмийн зэвсэггүй бүс нь бүс нутгийн аюулгүй байдалтай шууд холбоотой.
- Манай орны олон улсын нэр хүндийг өсгөн нэмэгдүүлэхийн зэрэгцээ, энэхүү бодлого нь Монгол улсын аюулгүй байдлыг улам баталгаатай болгож байгаа юм²⁴.

Харин судлаач Ж.Энхсайханы үзэж байгаагаар Монгол улс нэг улс-цөмийн зэвсэггүй бүсийн статусаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж, олон улсын эрх зүйгээр баталгаажуулах нь цөмийн зэвсэггүй бүсийн эдэлдэг олон төрлийн давуу тал, түүний дотор “Үл дэлгэрүүлэх гэрээ”-ний хяналтын дэглэмээс илүү хатуу аюулгүй байдлын баталгааг эдлэх, цөмийн эрчим хүч, шинжлэх ухааны ололт амжилтыг энх тайвнаар ашиглахад дэмжлэг авах боломжтой болох явдал юм. Түүнээс гадна энэ нь газар зүйн болон геополитикийн байршлаасаа шалтгаалан уламжлалт цөмийн зэвсэггүй бүсэд нэгдэн орох боломжгүй бусад улс орнуудад үлгэр жишээ болох болно²⁵. Тэрээр мөн “Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь ЗХА-ийн аюулгүй байдлын чухал элемент болж чадна”²⁶ хэмээн үзэж байгаа юм.

Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат “Зүүн Хойд Азийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах үйл явц удааширч байгаа нөхцөлд цөмийн шүхрийн хамгаалалтад байдаг тус бүсийн улс орнууд түүнээсээ татгалзаж, нэг улс-Цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс аюулгүй байдлын баталгаа авах”-ыг санал болгосон²⁷. Энэ нь нэг улс-Цөмийн зэвсэггүй бүсийн ач холбогдлыг өргөсөн чухал санаачилга болсон билээ.

Цөмийн зэвсэггүй бүсүүд өргөжин тэлэх боломж хязгаарлагдмал байгаа талаар Японы судлаач Масацугу Мацуо “Энэ нь нэг талаар цөмийн хөлөг онгоцоо чөлөөтэй зорчих явдлыг хангах хүсэлтэй цөмийн гүрнүүд болон нөгөө талаар цөмийн зэвсэгтэй болох “нээлттэй боломжтой” байхыг хүссэн цөмийн зэвсэггүй улсуудын үл оролцооноос шалтгаалдаг”²⁸ хэмээн дүгнэсэн байдаг нь үндэстэй юм. Тийм ч учраас өөрийн нутаг дэвсгэрээ дангаараа цөмийн зэвсэггүй

²⁴ С.Галсанжамц, Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, Стратеги судлал сэтгүүл, 2002 №2

²⁵ Blue Banner NGO, Single State NWFZ: Progress and Prospects, Ulaanbaatar 2007, p.67

²⁶ J.Enkhsaikhan. Mongolia's non-nuclear-status-an important element of Northeast Asia security. UB.15 Februar 2006.p.10

²⁷ P.Ochirbat, Mongolia's Efforts toward Peace and Stability in North East Asia, The Mongolian Journal of International Affairs, No.14, Ulaanbaatar 2007, p.31

²⁸ Masatsugu Matsuo, Peace and Conflict Studies: A Theoretical Introduction, Hiroshima 2005 p.99

бүс болгон зарласан манай улсын санаачилга шинээр цөмийн зэвсэггүй бүс байгуулах буюу нэгдэн ороход бэрхшээл тулгарч байгаа орнуудад үлгэр дууриал болж байгаагаараа ач холбогдолтой юм.

Гэхдээ Монгол улс өнөөгийн байдлаар зөвхөн улс төрийн мэдэгдлүүдээр дэмжүүлсэн цөмийн зэвсэггүй бүсийн статусаа олон улсын эрх зүйгээр баталгаажуулах зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд юуны өмнө цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс аюулгүй байдлын эрх зүйн үндэстэй баталгаа авах ёстой. Одоогийн байдлаар цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс цөмийн зэвсэггүй орнуудад аюулгүй байдлын негатив ба позитив баталгаа гаргаж өгдөг.

Аюулгүй байдлын негатив баталгаа гэдэг нь цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс цөмийн зэвсгээс албан ёсоор татгалзсан орнуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх, цөмийн зэвсэг хэрэглэхээр заналхийлэхгүй байх үүрэг амлалт юм. Цөмийн зэвсэггүй улсууд уламжлал ёсоор тийм баталгааг гэрээний хэлбэрээр авахыг эрмэлздэг.

Аюулгүй байдлын позитив баталгаа гэдэг нь хэрэв цөмийн зэвсэггүй улсууд цөмийн зэвсэгт халдлагын золиос болох буюу цөмийн зэвсгийн заналхийлэлд өртвөл цөмийн зэвсэгтэй улсуудын зүгээс тусламж үзүүлэх талаар цөмийн зэвсэгтэй болон цөмийн зэвсэггүй улсуудын хооронд байгуулсан тохиролцоо юм²⁹.

“Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ” нь цөмийн зэвсгийг бүрэн устгах зорилготой хэдий ч уг зорилгодоо хүрээгүй байгаа цагт аюулгүй байдлын баталгаа зайлшгүй шаардлагатай юм. Цөмийн зэвсэггүй улсуудын хүчин чармайлтыг эс хайхран ОХУ, Их Британи, АНУ, Франц зэрэг цөмийн зэвсэгтэй гүрнүүд ийм баталгаа өгөхөөс зайлсхийсээр байна. Зөвхөн БНХАУ “хэдийд ч, ямар ч нөхцөл байдалд цөмийн зэвсгийг анхлан хэрэглэхгүй”³⁰ гэсэн баталгаа өгсөн юм. Тийм ч учраас цөмийн зэвсэггүй олон орон аюулгүй байдлын негатив баталгааны тухай олон улсын эрх зүйн заавал дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон олон улсын гэрээ байгуулахыг шаарддаг билээ.

Монгол улсын зүгээс цөмийн зэвсэггүй бүсийн статусаа баталгаажуулахаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндэсний хэмжээнд болон хоёр ба олон талт хамтын ажиллагааны хүрээнд нэлээдгүй үр дүнд хүрээд байна.

Үндэсний хэмжээнд хүрсэн үр дүн

Монгол улс цөмийн зэвсэггүй бүсийн статусаа баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт тавьж ирсэн бөгөөд 1994 онд УИХ-аас батлан гаргасан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын хэмжээнд баталгаажуулж, аюулгүй байдлаа улс төрийн аргаар бэхжүүлэх чухал тулгуур болгох”³¹ нь Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах арга замын нэг гэдгийг тодорхойлсон юм.

2000 онд УИХ-аас “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” хууль, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 19-р тогтоолыг баталснаар

²⁹ <http://www.reachingcriticalwill.org/legal/NSA.htm>

³⁰ Premier Chou-En-Lai's message on 17 October 1964 to the Heads of Governments in Peking Review, Vol. VII, No. 43, 23 October 1966, p. 6.

³¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Улаанбаатар 1994, 23-р зүйл

Монгол улс цөмийн зэвсэггүй бүсийн статусаа үндэсний хэмжээнд баталгаажуулж чадсан гэж үзэж болно. Уг хуулиар Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хяналтандаа байлгах, байрлуулах, аливаа хэрэгслээр тээвэрлэх, туршилт хийх, цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах, устгахыг хориглосон бөгөөд энэхүү хууль нь Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, дэмжлэг хүртэхэд чухал түлхэц болсон юм³². Мөн 2000 онд “Орчинд аюултай хог хаягдлыг оруулах, тээвэрлэх, гаргах тухай” хууль, 2001 онд “Цацраг идэвхт бодисын хадгалалт, хамгаалалтын тухай” хуулиудыг батлан гаргасан нь цөмийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн дорвитой алхам болсон билээ.

Түүнчлэн манай улс цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийн хүрээнд батлагдан гарсан олон улсын гэрээ, конвенцид идэвхтэй нэгдэж, соёрхон баталсаар ирснийг дурдах ёстой. 1968 оны “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ”-нд цөмийн зэвсэггүй улс статустай нэгдсэнээс хойш холбогдох бараг бүх гэрээ конвенцид нэгдээд байна. Тухайлбал, “Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай” 1996 оны гэрээнд нэгдэж, 1997 онд соёрхон баталсан³³ бөгөөд 1997 оны “Цөмийн шаарын аюулгүй байдал ба цацраг идэвхт хаягдлыг зохицуулах хамтарсан конвенци”-д нэгдсэн.³⁴

Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах асуудлаар авч хэрэгжүүлсэн өөр нэг чухал алхам нь 2001 оны 12-р сард Цөмийн Энергийн Комиссын дүрмийг шинэчлэн баталсан явдал юм. Мөн 2005 онд “Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенци”-д гарын үсэг зурсан.

Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд хүрсэн үр дүн

1993-1994 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн талаар тус бүрдээ мэдэгдэл хийсэн билээ. Эдгээр мэдэгдлүүдээр ОХУ, БНХАУ, Франц, АНУ, Их Британи улс нь манай улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэх үүрэг хүлээж, цөмийн зэвсэггүй улсуудын аюулгүйн баталгааны талаар гаргасан өмнөх мэдэгдлүүдээ Монгол улсын хувьд дахин нотолж байгаагаа илэрхийлсэн байдаг.

Түүнчлэн Монгол улс, ОХУ-ын Ерөнхийлөгч нарын 2000 онд гарын үсэг зурсан Улаанбаатарын тунхаглал, Монгол-Энэтхэгийн 2004 оны хамтарсан мэдэгдэл, Монгол-АНУ-ын 2004 оны мэдэгдэл, Монгол-БНХАУ-ын 2004 оны хамтарсан мэдэгдэл зэрэг олон баримт бичигт хоёр талын харилцаанд Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэх, дэмжихээ илэрхийлсэн³⁵.

БНАСАУ-аас бусад ЗХА-ийн бүх улс манай улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжихээ илэрхийлсэн юм. Үүнээс гадна 2000 оны 11-р сард Японы төлөөлөгч 2000, 2002 оны 10-р сард Энэтхэгийн төлөөлөгч тус тус НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулган дээр хэлсэн үгэндээ Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжсэн байр сууриа илэрхийлж байсан. 2004 онд 10-р сард

³² А.Нандинчимэг, “Цөмийн зэвсэггүй бүс ба Монгол Улсын бодлого”, УБ 2007

³³ Т.Ариунсанаа. Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус. УБ.2001, 25-р тал

³⁴ Д.Мөнх-Очир. Монгол улсын хил орчмын цөмийн хаягдлын холбогдолтой асуудал.//”Стратеги судлал” 2004 №2, 100-р тал

³⁵ “Монгол улсын гадаад бодлогын хөх ном”. ГХЯ. УБ.2006, 55-р тал

Монгол улсын ерөнхийлөгч, Канадын Ерөнхий сайд нарын хамтарсан мэдэгдэлд “...Канад улс Монгол улсын цөмийн зэвсэггүй статус болон түүнийгээ эрх зүйн үндэстэй болгох талаар гаргаж буй хүчин чармайлтыг бүрэн дэмжиж”³⁶ байгаагаа илэрхийлснийг дурдах нь зүйтэй.

2006 оны 5-р сард БНСУ-ын Ерөнхийлөгч Ну Мү Хён “Цөмийн зэвсгээс ангид байх статусаа олон улсын хэмжээнд баталгаажуулах талаар Монгол улсын тавьж буй хүчин чармайлт нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх горимыг бэхжүүлэх, ЗХА болон бусад бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах чухал арга хэмжээ гэж үзэж, түүнийг БНСУ дэмжиж байгаа”³⁷ хэмээн мэдэгдсэн.

Эдгээр мэдэгдлүүд дотроос цөмийн зэвсэгтэй манай хоёр хөршийн мэдэгдэл чухал байр суурь эзэлдэг. Тухайлбал, ОХУ-ын ерөнхийлөгч В.Путинийг Монголд айлчлах үеэр 2000 оны 11 сарын 14-нд гаргасан хамтарсан тунхаглалд “Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан тус улсын аюулгүй байдлын баталгааны талаар цөмийн зэвсэгтэй таван гүрний хамтран гаргасан мэдэгдлийн үзэл санааг Орос улс тууштай сахин баримтлахаа нотлож байна”³⁸ хэмээн дурдсан. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярыг ОХУ-д айлчлах үеэр гаргасан Монгол-Оросын хамтарсан албан мэдээнд “Цөмийн зэвсэггүй статусаа бэхжүүлэх талаар Монгол улсын тавьж буй хүчин чармайлтыг Орос улс Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний дагуу цөмийн зэвсэггүй орны нь хувьд Монгол улсад олгогдсон, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1995 оны 4 дүгээр сарын 11-ний 984 дүгээр тогтоолоор болон НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн-цөмийн таван гүрний 2000 оны 10 дугаар сарын 5-ны Хамтарсан мэдэгдэлд тусгагдсан аюулгүй байдлын баталгааг нотлож байна”³⁹ гэдгээ илэрхийлсэн.

2004 оны 7-р сарын 6-ны Монгол-Хятадын хамтарсан мэдэгдэлд “...талууд Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал юм гэж үзэв. Статусаа баталгаажуулах талаар Монгол улсын гаргаж буй хүчин чармайлтыг Хятадын тал дэмжиж байна”⁴⁰ гэдгээ илэрхийлсэн.

Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь цөмийн зэвсэгтэй манай хоёр хөршийн улс төрийн дэмжлэгээс ихээхэн хамаарахаас гадна тэдгээрээс олон улсын эрх зүйн үндэстэй баталгаа гаргуулж авах нь туйлын чухал билээ. Монгол улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны гэрээ, Монгол улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1994 оны гэрээ ёсоор нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид байлгах тухай Монгол улсын бодлогыг хүндэтгэж байх үүрэг амлалт авсан нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал эрх зүйн баталгаа болсон юм.

Энэ бүгдээс харахад Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг бүс нутгийн болон олон улсын нөлөө бүхий оролцогчид дэмжсэн байр суурьтай

³⁶ “Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн явцын тухай илтгэл”. Хавсралт 6. 2004 оны 10 сарын 21-ний Өргөтгөсөн түншлэлийн тухай Монгол-Канадын хамтарсан мэдэгдэл. 24-р тал

³⁷ Мөн тэнд., 2006 оны 5-р сарын 10 Монгол улс, БНСУ-ын хамтарсан мэдэгдэл

³⁸ “Монгол-Оросын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл”. УБ. 2006

³⁹ “Монгол-оросын хамтарсан албан мэдээ”, Москва хот, 2008 оны 4-р сарын 13-ны өдөр

⁴⁰ “Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн явцын тухай илтгэл”. Хавсралт 6. 24-р тал

байна. Тэр дундаа манай хоёр хөрш ОХУ ба БНХАУ энэ асуудлаар дэмжсэн байр сууриа удаа дараа илэрхийлж, хоёр талын харилцааны үндсэн зарчмыг тодорхойлсон тулгуур гэрээнүүдэд үүрэг хүлээхээр тусгасан байгаа нь Монгол улс цөмийн зэвсэггүй статусаа олон улсын эрх зүйгээр баталгаажуулж, цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс буюу хоёр хөршөөсөө хамтарсан эрх зүйн баталгаа авахад таатай нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд хүрсэн үр дүн

1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53-р чуулганаар “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай 53/77/D тоот тогтоолыг батлан гаргаж, олон улсын хэмжээнд манай улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэх, дэмжихийг уриалсан билээ. Дээрх тогтоолоос гадна НҮБ-ын Ерөнхий Ассамблей Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүлээн зөвшөөрч бэхжүүлэхэд чиглэсэн тогтоолыг 1998, 2000, 2002, 2004, 2006 онуудад хэлэлцэн баталсан. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга мөн онуудад Монголын цөмийн зэвсэггүй статусын асуудлаар 4 удаа илтгэл хэлэлцүүлснийг дурдах ёстой.⁴¹ Тухайлбал, 2000 онд Монгол улсын “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” хуультай танилцсаны дагуу Ерөнхий Ассамблейн 55-р чуулганаас A/55/56/S/2000/160 тогтоолыг баталсан байдаг.⁴² Үүнээс харахад, НҮБ-ын зүгээс Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх талаар хамтран ажиллахыг гишүүн орнуудад уриалж, идэвхтэй байр суурь баримталсаар ирсэн юм.

2001 онд НҮБ-ын Зэвсэг хураах асуудал эрхэлсэн газар Энх тайван, зэвсэг хураах АНД-н бүсийн төвийн Катманду болон Нагасакид болсон уулзалт, семинаруудаар Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг дэлгэрэнгүй танилцуулж, дэмжихийг уриалсан⁴³.

Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхэд НҮБ-аас гадна Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн (ЭҮНХ) чухал үүрэг гүйцэтгэж ирснийг тэмдэглэх ёстой. Тухайлбал, 2000 онд гаргасан ЭҮНХ-ий сайд нарын тунхаглалд Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг “үл дэлгэрүүлэх дэглэмийг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хүчин чармайлтанд бодитойгоор хувь нэмэр оруулсан явдал”⁴⁴ хэмээн сайшаан дэмжсэн юм. Түүнчлэн эвсэлд нэгдээгүй орнуудын сайд нарын 2002 оны хуралдаанаас гаргасан албан мэдээндээ Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжиж байгаагаа дурдаад “эл статусыг хуульчлан баталгаажуулах нь үл дэлгэрүүлэх дэглэмийг бүс нутагт бэхжүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ” болохыг онцолсон ба 2003 оны 2-р сард ЭҮНХ-ний 114 орны төр, засгийн тэргүүн нарын хурлаас Монгол улсын статусыг олон улсын эрх зүйн үндэстэй болгохыг дэмжсэн билээ.⁴⁵

“Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ”-ний биелэлтийг хянан хэлэлцэх бага хурал, АСЕАН-ы бүсийн чуулганы сайд нарын уулзалтаас гаргасан

⁴¹ “Монгол улсын гадаад бодлогын хөх ном”. ГХЯ. УБ.2006, 55-р тал

⁴² <http://www.opanal.org/NWFZ/Mongolia>

⁴³ “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай НҮБ-ын ЕНБДаргын илтгэл”, “Стратеги судлал” сэтгүүл, 2002 №2, 161-р тал

⁴⁴ “Монгол улсын гадаад бодлогын хөх ном”. ГХЯ. УБ.2006, 55-р тал

⁴⁵ “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай НҮБ-ын ЕНБДаргын илтгэл”, “Стратеги судлал” сэтгүүл, 2002 №2, 162-р тал

мэдэгдлүүд зэрэгт Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжсэн заалтууд орсон байдаг. Тухайлбал, Ази-Номхон далайн бүсийн зэвсэг хураах 1999, 2000 оны бага хурлуудаар уг асуудлыг авч хэлэлцэн, дэмжсэн юм.

Түүнчлэн, 2002 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын уулзалтаас гаргасан Санктпетбургийн тунхаглалд Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэн дэмжиж байгаагаа илэрхийлсэн.⁴⁶

2005 оны 2-р сард Зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх дэлхий нийтийн түншлэл (GPPAC)-ийн ЗХА-ийн бүсийн үйл ажиллагааны хөтөлбөрт “Монголын санаачлага нь асуудалд бодитойгоор хандахын жишээ мөн бөгөөд уламжлалт бус цөмийн зэвсэггүй статусыг буй болгоход эерэг үлгэр жишээ болж байна” хэмээн үнэлсэн билээ.⁴⁷

2005 оны 4-р сард Мехико хотноо зохион байгуулагдсан Цөмийн зэвсэггүй бүсүүдийн орнуудын анхдугаар хуралд Монгол улс бүрэн эрхт гишүүнээр уригдаж оролцсон бөгөөд тус хурлаас “бид Монгол улсын олон улсын цөмийн зэвсэггүй статусыг хүлээн зөвшөөрч бүрэн дэмжиж байна”⁴⁸ хэмээн мэдэгдсэн нь олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс манай улсын цөмийн зэвсэггүй статусыг хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаагийн илэрхийлэл болсон.

Ийнхүү Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс идэвхтэй дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч уг статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулахад дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж байгаа билээ.

Олон улсын эрх зүйн баталгааны тухайд

2000 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн бөгөөд цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусын талаар аюулгүй байдлын улс төрийн баталгаа гаргасан хамтарсан мэдэгдэл хийсэн юм.⁴⁹ Уг мэдэгдлээр цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй, хэрэглэхээр заналхийлэхгүй бөгөөд тийм аюул занал учирвал Монгол улсад туслах амлалт авсан. Цөмийн зэвсэгтэй таван гүрэн нэгдсэн байр суурьтайгаар нэг улс-цөмийн зэвсэггүй бүсэд аюулгүйн баталгаа өгөх үндсэн шалтгаан нь Монгол улс “Үл дэлгэрүүлэх гэрээ”-нд оролцогч, цөмийн зэвсэггүй, газар зүйн нэн онцгой байдалтай улс болохыг онцолсон байдаг⁵⁰. Гэвч энэхүү мэдэгдэл нь олон улсын гэрээний адил хүчин төгөлдөр мөрдөгдөх эрх зүйн үндэсгүй юм. Иймд цөмийн зэвсэггүй статусаа олон улсын эрх зүйн үндэстэй бүрэн баталгаа олж авах зорилгоор манай улс НҮБ-тай нягт хамтран ажиллаж ирсэн билээ.

2002 оноос хойш Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах талаар манай төрийн бодлого зогсонги төлөвт ороод

⁴⁶ “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай НҮБ-ын ЕНБДаргын илтгэл”, “Стратеги судлал” сэтгүүл, 2002 №2, 162-р тал

⁴⁷ Ц.Амгалан. “Ж.Энхсайхан.Сэвтээ нь үгүй сэтгэл”. “Гоо даль” сэтгүүл, 2005 оны 12 сар.№6, 33-р тал

⁴⁸ Report of the Secretary General, “Mongolia’s International Security and Nuclear-weapon-free Status”, United Nations A/RES/61/164

⁴⁹ United Nations A/55/530-S/2000/1052

⁵⁰ Statement on Security Assurances in Connection with Mongolia’s Nuclear-Weapon –Free-Status. “The security of Small State:Option for Mongolia” by R.Bold, UB.2000, 44p

байсныг “Цэнхэр сүлд” төрийн бус байгууллагын санаачилгаар ахин сэргээж, уг асуудлыг олон нийтэд сурталчлан таниулах, бусад улсуудтай хамтран ажиллах талаар тодорхой алхмуудыг хийж буйг дурдах нь зүйтэй⁵¹.

2001 оны 9-р сард Японы Саппоро хотноо АНУ, ОХУ, Франц, Их Британи, БНХАУ зэрэг цөмийн гүрнүүд, Монгол улс болон НҮБ-ын шинжээчид уулзаж, Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргасан. Шинжээчид дараах асуудлыг тал бүрээс нь хэлэлцэн, дүн шинжилгээ хийжээ. Үүнд:

-Одоогийн байдлаар Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статус олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эсэх;

-Хэрэв тийнхүү хүлээн зөвшөөрөгдсөн бол хууль зүйн хувьд хэрхэн илэрхийлэгдэж байгаа;

- Хэрэв тийнхүү хүлээн зөвшөөрөгдөөгүй бол уг статусыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх талаар чухам юу хийх шаардлагатай.

Шинжээчдийн дүгнэн үзсэнээр Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг одоогийн байдлаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөөгүй байгаа бөгөөд тийнхүү хүлээн зөвшөөрүүлэх ямар ямар арга зам байгааг тодорхойлоход хүчин чармайлт тавих хэрэгтэйг зөвлөсөн⁵².

Түүнчлэн шинжээчид Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах гэрээний хоёр төрлийн загвар байж болно хэмээн үзсэн юм. Үүнд:

- Хязгаарлагдмал гэрээ. Монгол улс цөмийн зэвсэгтэй хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай тус улсын нутаг дэвсгэрт цөмийн зэвсгийг үл байрлуулах, үл хадгалах, үл дамжин өнгөрүүлэх үүрэг хүлээсэн гэрээ байгуулах.
- Дэлгэрэнгүй гэрээ. Энэ нь аюулгүй байдлын илүү өргөн хүрээтэй асуудлыг тухайлбал, аюулгүйн баталгаа, цөмийн дэлбэрэх хэрэгслийг турших, цөмийн шаарыг булшлах, бусад төрлийн үй олноор хөнөөх зэвсэг болон тэдгээрийг тээвэрлэх хэрэгсэл, ердийн цэрэг зэвсгийн хүчин чадал, цэргийн бус аюул занал гэх мэтийг багтаана⁵³.

Нөгөө талаар, Саппород цугласан шинжээчид дээрх хоёр загварын хооронд олон төрлийн хувилбар, боломж байж болохыг үгүйсгээгүй. Шинжээчид хязгаарлагдмал гэрээнд дараах зүйлийг багтааж болох юм хэмээн үзсэн. Үүнд:

- Ийм гэрээ байгуулахыг эрэлхийлж буй Монгол улсын зорилгыг тодорхойлсон оршил хэсэг,
- Монгол улс өөрийн нутаг дэвсгэр дээр болон нутаг дэвсгэрээр дамжуулан цөмийн дэлбэрэх хэрэгслийг байрлуулах, хадгалах, дамжин өнгөрүүлэх буюу тийм оролдлого хийхийг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээж буйг тодорхойлсон гол хэсэг,
- Гэрээний хугацаа, төгсгөл болох, нэр томъёо, хүчин төгөлдөр болох зэргийг заасан заалт.

Шинжээчид дэлгэрэнгүй гэрээнд дараах зүйлийг багтааж болох юм хэмээн үзсэн. Үүнд:

- Дээр дурдсантай ижил утгатай оршил хэсэг,

⁵¹ А.Нандинчимэг, “Цөмийн зэвсэггүй бүс ба Монгол Улсын бодлого”, УБ 2007.

⁵² United Nations A/55/530-S/2000/1052

⁵³ Ibid

- Монгол улс өөрийн нутаг дэвсгэр дээр болон нутаг дэвсгэрээр гадаадын цэргийн хүч, зэвсэг техник, цөмийн болон бусад үй олноор хөлөөх зэвсэг, тэдгээрийг тээвэрлэх хэрэгслийг байрлуулах, хадгалах, дамжин өнгөрүүлэхийг хориглох үүрэг хүлээж буйг заасан гол хэсэг,
- Үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч 5 цөмийн гүрэн Монгол улсын нутаг дэвсгэр дээр болон нутаг дэвсгэрээр дамжуулан өөрсдийн цэргийн хүч, зэвсэг техник, цөмийн болон бусад үй олноор хөнөөх зэвсэг, тэдгээрийг тээвэрлэх хэрэгслийг байрлуулах, хадгалах, дамжин өнгөрүүлэхийг хориглох үүрэг хүлээж буйг заасан гол хэсэг.
- Монголын газар нутаг дээр цөмийн хэрэгслийг туршихгүй байх тухай заалт,
- Монголын газар нутаг дээр цөмийн хог шаар булшлахгүй байх тухай заалт,
- Гэрээг хянах механизм бий болгох тухай заалт,
- Гэрээний хугацаа, төгсгөл болох, нэр томъёо, хүчин төгөлдөр болох зэргийг заасан заалт.⁵⁴

Түүнчлэн Саппорогийн уулзалтад оролцсон шинжээчид “Хэрвээ Монгол улс өөрийн цөмийн зэвсэггүй статусаа эрх зүйн хүчинтэй баримт бичгийн хэлбэрээр олохыг хүсвэл хязгаарлагдмал, чиглэгдсэн эрх зүйн баримт бичигт илүү анхаарал төвлөрүүлэн хурдан, энгийнээр хийх нь илүү зүйтэй”⁵⁵ хэмээн зөвлөсөн юм. Энэхүү зөвлөмжийн дагуу 2002 онд Монгол улс хоёр хөршдөө “Монгол улсын цөмийн зэвсэггүй статусын талаар Монгол улс, БНХАУ, ОХУ-ын хооронд байгуулах гэрээний үндсэн элементүүд” нэртэй гурван талт гэрээнд тусгаж болох саналуудыг өргөн барьсан юм. Үүний хариуд мөн оны 4-р сард БНХАУ, 7-р сард сард ОХУ тус тус зарчмын хувьд зөвшөөрч байгаагаа илэрхийлж, гэрээнд тусгах өөрсдийн саналыг өгсөн. Эдгээр саналыг тусгасан гэрээний төслийг Монголын тал боловсруулж, 2007 оны 9-р сард ОХУ ба БНХАУ-ын Элчин сайд нарт гардуулсан билээ.

Уг төсөлд цөмийн зэвсэггүй бүс байгуулах олон улсын гэрээнд тусгагддаг үндсэн зарчмуудаас гадна цөмийн зэвсэгтэй хоёр гүрэнтэй хиллэдэг Монгол улсын онцгой нөхцөл байдлыг харгалзан үзсэн. Төсөлд Монгол улсын болон хөрш хоёр улсын зүгээс хүлээх үүргүүдийг тодорхойлсноос гадна Монгол улсын ЦЗБ-ийн статусыг бэхжүүлэх талаар хамтран ажиллах, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн материалаас хамгаалах, цөмийн үйл ажиллагааны талаар мэдэгдэх, цөмийн осол болсон тохиолдолд цаг алдалгүй мэдэгдэх зэрэг асуудлыг мөн тусгасан⁵⁶.

Аливаа цөмийн зэвсэггүй бүсийг байгуулах гэрээнд оролцогч талуудын хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхэд үр дүнтэй, тал бүрийн, найдвартай хяналт шаардлагатай байдаг.⁵⁷ Гэхдээ энэхүү төсөлд гэрээний хэрэгжилтийг

⁵⁴ United Nations A/55/530-S/2000/1052

⁵⁵ Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх арга замууд: 2001 оны 9-р сарын 5-6-нд Япон улсын Саппоро хотод НҮБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан, засгийн газрын бус шинжээчдийн уулзалтаас гаргасан баримт бичиг, “Стратеги судлал” сэтгүүл, 2002 №2

⁵⁶ <http://www.mfa.gov.mn>

⁵⁷ В. Алексеев, Безъядерные зоны - важный фактор европейской безопасности <http://zw-observer.narod.ru>

хянах бие даасан хяналтын механизм бий болгох талаар дурдаагүй бөгөөд энэ үүргийг Монгол улсын Цөмийн энергийн комисс, Олон улсын Цөмийн энергийн комисстой хамтран хэрэгжүүлэх юм.

Түүнээс гадна энэхүү гэрээ нь хавсралт протоколтой байх бөгөөд тэрхүү протоколд албан ёсоор цөмийн зэвсэгтэй улсад тооцогддог бусад гурван улс гарын үсэг зурахад нээлттэй юм. АНУ, Их Британи, Франц зэрэг улсууд энэ протоколд гарын үсэг зурснаар Монгол улс, ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулагдсан гурван талт гэрээг мөрдөж, бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүрэг хүлээх юм.

Монгол улсын хувьд энэхүү гурван талт гэрээг цаг алдалгүй байгуулж, хэрэгжилтийг хангахын тулд хөрш хоёр оронтойгоо нягт хамтран ажиллаж, улс төрийн хүчин чармайлтаа улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлтийн оронд

Монгол улс Үндсэн хуулиндаа тунхагласан энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах үзэл санааны үндсэн дээр улс орныхоо аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар сахин хамгаалах зарчмын хүрээнд хийгдсэн улс төрийн зоригтой алхам бол өдгөөгөөс 16 жилийн өмнө нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан явдал билээ. Энэ нь нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс байгуулж болох талаар 1975 онд НҮБ-ын "Цөмийн зэвсэггүй бүсүүдийн асуудлаарх цогц судалгаа"-нд дурдагдсан үзэл санааг амьдрал дээр бодитойгоор хэрэгжүүлж эхэлсэн анхны тохиолдол болсон юм. Газар зүйн байршил, геополиток болон улс төрийн бусад шалтгаанаас үүдэн уламжлалт цөмийн зэвсэггүй бүсийн бүрэлдэхүүнд багтах бололцоогүй олон орны хувьд нэг улс-цөмийн зэвсэггүй бүсийн статусаа олон улсын эрх зүйгээр баталгаажуулах талаар тавьж буй Монгол улсын хүчин чармайлт үлгэр дууриал болж байгаа билээ. Хэрэв манай улс энэхүү статусаа олон улсын эрх зүйгээр бүрэн дүүрэн баталгаажуулж чадвал Австри, Афганистан, Балба, Беларус, Кипр, Исланд, Мальт, Украин, Япон зэрэг олон орон уламжлалт бус буюу нэг улс-цөмийн зэвсэггүй бүс байгуулах боломж бүрдэх юм.

Хэдийгээр цөмийн зэвсэггүй бүсийн статусаа олон улсын эрх зүйгээр баталгаажуулах нь Монгол улсыг цөмийн аюул заналаас 100 хувь сэргийлж чадахгүй боловч тэрхүү аюулыг маш их хэмжээгээр бууруулж, цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцийг бий болгоход дорвитой хувь нэмэр болж чадна. Тийм ч учраас Монгол улсын цөмийн зэвсэггүй статусын талаар манай улс хөрш хоёр оронтойгоо олон улсын эрх зүйн дагуу заавал дагаж мөрдөх шинж чанартай гурван талт гэрээ байгуулах ажлаа улам эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нөгөөтэйгүүр ОХУ болон БНХАУ-ын цөмийн туршилт хийдэг байсан талбайнууд манай нутаг дэвсгэрээс холгүй оршдог бөгөөд цөмийн туршилтаас үүдэлтэй цацраг идэвхт бодисын хор хөнөөл манай хил орчмын нутгийн байгаль орчин, хүн амд хэрхэн нөлөөлсөн буюу нөлөөлж байгаа талаар тусгайлан судалгаа хийх шаардлага нэгэнт бий болоод байгааг дахин тэмдэглэе.

Ном зүй

Монгол хэлээр:

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, "Олон улсын эрх зүй", Улаанбаатар 1999
2. Т.Ариунсанаа, "Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус", УБ 2001
3. Д.Мөнх-Очир, "Монгол улсын хил орчмын цөмийн хаягдлын холбогдолтой асуудал", Стратеги судлал сэтгүүл 2004 '2
4. Ц.Амгалан, "Ж.Энхсайхан:Сэвтээ нь үгүй сэтгэл", Гоо даль сэтгүүл 2005 оны 12 сар '6
5. А.Нандинчимэг, "Цөмийн зэвсэггүй бүс ба Монгол Улсын бодлого", УБ 2007 (магистрын зэрэг горилсон дипломын ажил)
6. Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх арга замууд: 2001 оны 9-р сарын 5-6-нд Япон улсын Саппоро хотод НҮБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан, засгийн газрын бус шинжээчдийн уулзалтаас гаргасан баримт бичиг, "Стратеги судлал" сэтгүүл, 2002 '2
7. Монгол Улсын ГХЯ, "Монгол улсын гадаад бодлогын хөх ном", УБ 2006
8. "Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн явцын тухай илтгэл"
9. "Монгол-Оросын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл", УБ 2006
10. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, УБ 1994
11. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ 1994
12. "Монгол-оросын хамтарсан албан мэдээ", Москва хот, 2008 оны 4-р сарын 13-ны өдөр

Англи хэлээр

1. Mohamed Ibrahim Shaker, *The Evolving International Regime of Nuclear Non-Proliferation*, Belles pages shaker ok.qxd 2007
2. Peter Malanczuk, *Akehurst's Modern Introduction to International Law*, 7th revised edition, Routledge 1997.
3. John T.Rourke, *International Politics on the World Stage*, 9th Edition, McGraw-Hill/Dushkin 2003
4. Masatsugu Matsuo, *Peace and Conflict Studies: A Theoretical Introduction*, Hiroshima 2005
5. IPPNW North Asian Regional Meeting: Documents and Proceedings, 21-22 June, 2007, Ulaanbaatar, Mongolia
6. Blue Banner NGO, *Single State NWFZ: Progress and Prospects*, Ulaanbaatar 2007
7. New York Times, 22 January 1985
8. J.Enkhsaikhan, *Mongolia's Non-nuclear-status-An Important Element of Northeast Asia security*, Ulaanbaatar 2006
9. P.Ochirbat, *Mongolia's Efforts toward Peace and Stability in North East Asia*, *The Mongolian Journal of International Affairs*, No.14, Ulaanbaatar 2007
10. United Nations A/55/530-S/2000/1052
11. R.Bold, *The Security of Small States: Option for Mongolia*, Ulaanbaatar 2000
12. Premier Chou-En-Lai's message on 17 October 1964 to the Heads of Governments in Peking Review, Vol. VII, No. 43, 23 October 1966, p. 6.
13. Stockholm International Peace Research Institute, *SIPRI Yearbook 2008 : Armaments, Disarmament and International Security*, Sweden 2008
14. United Nations A/55/530-S/2000/1052
15. Ian Traynor, *Pre-Emptive Nuclear Strike a Key Option*, *Nato Told*, *The Guardian*, 22 January 2008.
16. George P. Shultz, William J. Perry, Henry A. Kissinger and Sam Nunn, *A World Free Of Nuclear Weapons*, *The Wall Street Journal*, 4 January 2007

Герман хэлээр:

1. H. Möller, K. Frank, A. Kelle, S. Meier und A. Schaper: Nukleare Abrüstung - mit welcher Perspektive? Der internationale Diskurs über die nukleare Rüstungskontrolle und die Vision einer kernwaffenfreien Welt, HSFK-Report 8/1996
2. Wolfgang Kytter, Nuklear Terrorismus :Geklaut wird überall, Freitag 16, 21.April 2006

Орос хэлээр:

1. "Всемирная история" Т.24, Минск 1997
2. В. Алексеев , Безъядерные зоны - важный фактор европейской безопасности <http://zw-observer.narod.ru>

Вэб хуудас:

1. <http://www.mfa.gov.mn>
2. <http://www.reachingcriticalwill.org/legal/NSA.htm>
3. <http://www.opanal.org/NWFZ/Mongolia>
4. <http://nuclearweaponarchive.org/Russia/Sovtestsum.html>
5. http://en.wikipedia.org/wiki/List_of_nuclear_tests
6. <http://www.ctbto.org/map/#testing>
7. <http://www.icanw.org/nuclear-weapons-convention>
8. <http://www.uni-kassel.de/fb5/frieden/themen/Terrorismus/nuklear.html>
9. <http://www.guardian.co.uk/world/2008/jan/22/nato.nuclear>